

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2024/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Арвайхээр хот 2024 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2024.01.17 № 01

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд улсын төсвөөс 988.2 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 27.5 сая төгрөгийн санхүүжилт авч үндсэн данснаас цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний зардлыг, нэмэлт санхүүжилтийн данснаас шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын тусгай хэрэгсэл, хоригдол, ялтангуудад сургалт зохион байгуулахад зарцуулж 0.2 сая төгрөгийг, татан төвлөрүүлжээ.

Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 онд иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 904 гүйцэтгэх баримт бичгийн 6569.6 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 705 гүйцэтгэх баримт бичгийн 1607.8 сая төгрөгийг биелүүлж, 199 гүйцэтгэх баримт бичгийн 4961.8 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шийдвэрлэгдээгүй байна. Харин хөрөнгө болон торгох ялын 139 гүйцэтгэх баримт бичигт гүйцэтгэх ажиллагаа явуулж улсын төсөвт 181.7 сая төгрөгийг төвлөрүүлснээс орон нутгийн төрийн сангийн 100101900987 тоот дансанд 59.5 сая төгрөг, төв төрийн сангийн 100900012060 тоот дансанд 89.2 сая төгрөг, орон нутгийн 100100000988 тоот дансанд 33.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

015030044

D:\Auditin gazar\baiguullagin dotood barimt\A4

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант үеийн санхүүгийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  О БАТЖАРГАЛ



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/			
	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	79,754.9	57,064.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,269,706.8	1,269,350.8
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,349,461.7</b>	<b>1,326,415.2</b>
	Нийт өр төлбөрийн дүн	73,345.9	77,781.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,349,461.7	1,326,415.2
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,349,461.7</b>	<b>1,326,415.2</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	693,080.5	1,057,542.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	657,662.5	1,079,378.2
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>35,417.9</b>	<b>(21,835.3)</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	1,211.2
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>35,417.9</b>	<b>(23,046.5)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	115,881.2	115,881.2
	Тайлант оны үр дүн	35,417.9	(23,046.5)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,349,461.7</b>	<b>1,326,415.2</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	643,082.6	1,015,806.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	606,611.2	1,005,817.6
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>36,471.4</b>	<b>9,989.1</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(36,471.4)</b>	<b>(9,989.1)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	622,099.5	988,065.9
	Урсгал зардал	622,099.5	850,206.7
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	622,114.5	988,065.9
	Улсын төсвөөс санхүүжих	622,034.5	987,910.9
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.0	-
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80.0	155.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**



			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>								

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**